

СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.МӨНХХИШИГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин						
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5		6	7	
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах									
7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнана.	Сургалтын төв нь 2025 оны эхний хагас жилд дараах эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны өөрийн нэгжид хамаарах хэрэгжилтийн тайлан, мэдээг гаргаж, заасан хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд: - Сургалтын төвийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт; - Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт; - Гаалийн байгууллагын 2025 эхний хагас жилийн "Шударга байдлын үнэлгээ"-г сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт; - Гаалийн байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн биелэлт. Төвийн зүгээс 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаандаа хууль тогтоомж, гаалийн байгууллагын журам, дүрэм, бусад эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласнаас гадна ГЕГ-ын нэгжүүдээс ирүүлсэн дараах эрх зүйн актын төсөлд саналаа цаг хугацаанд нь дотоод зурвасаар хүргүүлсэн. Үүнд: - "Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль"-д санал боловсруулж хүргүүлсэн /2025.01.31/. - "Гаалийн албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн төсөлд санал боловсруулж Ёс зүйн дэд хороонд хүргүүлсэн /2025.03.25/. - Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-т санал боловсруулж өгсөн. - 2025 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс боловсруулсан "Гаалийн байгууллагын сургалтын журам"-д санал өгсөн /2025.06.05/.			01.01-06.10	100

				- ГХБГ-т ЗДАС программаар шинэчлэн боловсруулсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын төсөлд өгөх санал боловсруулж хүргүүлсэн /2025.04.07/. - ЗУГ-т ЗДАС программаар Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулж хүргүүлсэн /2025.05.16/. - ЗУГ-т "Гаалийн албан хаагчдын ажлын цагийг уян хатан байдлаар зохицуулах" асуудлаар санал авч нэгтгэн хүргүүлсэн.			
Зорилт 4. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"							
1	Сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлон, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. ГЕГ-ын ЗББНДБ, харъяа гаалийн газар, хороодын 2025 оны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа авч нэгтгэж, ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулах 2. Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 1 ажил зохион байгуулах 3. Заах арга зүйг боловсронгуй болгох хүрээнд жишиг сургалтын хөтөлбөр боловсруулах.	Сургалтын төвөөс ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар, хороодын 2025 оны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа авч нэгтгэн, ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан, ГЕГ-ын дарга Р.Отгонжаргалаар батлуулсан. /Файлыг CERP програмд байршуулсан./ Мөн ГЕГ-ын 2026 оны сургалтын төлөвлөгөөний саналыг ЗББНДБ-аас боловсруулуулан, нэгтгэж зардлын хамт СХОГ-т хянуулахаар хүргүүлсэн. Сургалтын төвийн багш бүр заах арга зүйг боловсронгуй болгох, жишиг сургалтын хөтөлбөр боловсруулах хүрээнд өөрийн заадаг хичээлээр сургалтын хөтөлбөрийг цаг үетэй нийцүүлэн боловсронгй болгож, шинэчилэн ажиллаж байна.. Мөн төвөөс "ГУБ нарыг чадавхжуулах дунд шатны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг шинээр боловсруулан, батлуулсан. Багш ГУБ Н.Нямгэрэл, Ж.Жаргал-Эрдэнэ, Г.Баярмаа "Озон задалдаг бодис, дэлхийн дулааралд өндөр нөлөөтэй гидрофторт нүүрстөрөгч болон тэдгээрийг орлуулах бодисын гаалийн эрсдэлийг тодорхойлох: Эрсдэлийн профайлын онол, арга зүй ба практик хэрэглээ" хичээлийн сургалтын хөтөлбөр боловсруулсан. Сургалтын орчин нөхцөлийг дэвшилтэт технологи ашиглан сайжруулах ажлын хүрээнд дараах 2 ажлыг хийсэн. Үүнд: - 210 тоот сургалтын танхимд шинээр 85inch ухаалаг дэлгэц ашиглан, сургалтаа явуулж эхэлсэн. - ГЕГ-ын ААҮА-д хүсэлт гаргасны дагуу сургалтын 206, 207, 210 тоот танхимуудад барилгын засвар, үйлчилгээг явуулж, мөн шинээр хөшгийг нь сольсон.	01.01-06.10	100
2	Албан хаагчдыг чадавхжуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт 2 удаа /80 суралцагч/,	Сургалтын төвөөс 2025 оны эхний хагас жилд ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө болон удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт – 2 удаа, ГУБ нарын мэргэшүүлэх сургалт – 4 удаа, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт – 3 удаа, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт – 3, VR мэргэшүүлэх сургалт -1,	01.01-06.10	100

				2. ГУБ нарын мэргэшүүлэх сургалт 2 удаа /50 ГУБ/, 3. Хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг чадавжуулах сургалт-1 удаа /30 ГУБ/ 4. ДГБ-ын Дунд түвшний удирдлагын хөгжил сургалт -1 удаа /60 ГУБ/ 5. Сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, зохион байгуулсан сургалтын тайланг нэгтгэн, үр дүн тооцсон байна.	цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалт-1 удаа, нийт 14 сургалтыг тус тус зохион байгуулсан ба сургалтад нийт 753 ажилтан, албан хаагч хамрагдаж, 99,2 хувийн амжилттай дүгнэгдсэн. Сургалт бүрийн өмнө сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийг боловсруулан, төвийн даргаар баталгаажуулж ажиллаж ирсэн. Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу Сургалтын төвийн үндсэн багш нараас гадна Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын чиглэл хариуцсан албан хаагч -зочин багш нар нийт 1575 цагийн хичээл заасан. Сургалт бүрийн төгсгөлд тухайн сургалтын тайлан, суралцагч нарын үнэлгээг ЗУГ болон чиглэл хариуцсан хэлтэст дотоод зурвасаар хүргүүлж байсан.		
3	Гааль судлалын хүрээнд хийгдсэн ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. МУИС-ийн багш нартай хамтран ГБМ-ийн сургалтын хөтөлбөр гаргана. 2. Гааль судлалын нэгдсэн санг баяуулах.	- 2025 оны эхний хагас жилд ГЕГ-аас МУИС-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд ГБМ-ийн анхан шатны сургалтын хөтөлбөр хамтран гаргаж, МУИС-ийн захирал профессор Н.Батнасангай хамтран баталсан. Энэхүү батлагдсан хөтөлбөрийн дагуу 2025 оны 5, 6 дугаар саруудад ГБМ-ийн анхан шатны 2 удаагийн сургалт явагдсан. - Гааль судлалыг хөгжүүлэх хүрээнд CERP програмд үүсгэн байршуулсан "Гааль судлал" дэд цэс"-д ДГБ-ын сэтгүүлд нийтлэгдсэн МУГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвийн үйл ажиллагаатай холбогдох материалыг оруулсан. - ГУАБ Л.Олонбаяр МУИС-ийн Бизнесийн сургуулиас 2025 оны 05 дугаар сарын 02-нд зохион байгуулсан МУИС-ийн захирал, доктор Я.Отгонсүрэнгийн нэрэмжит "Маркетинг, худалдааны хөгжлийн асуудлууд" үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд "Гадаад худалдааны нэг цонхны системийг хэрэгжүүлж бусад орнуудын туршлага. Монгол улсын авах сургагч" сэдвээр илтгэл тавьж, амжилттай хэлэлцүүлэн, батламж авсан. - ГУАБ Л.Олонбаяр МУИС-ийн Бизнесийн сургуулиас 2025 оны 05 дугаар сарын 16-нд зохион байгуулсан МУИС-ийн захирал, профессор, доктор Н.Батнасан, доктор Н.Отгонсайхан нарын нэрэмжит профессорын хэлэлцүүлэгт "Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг гадаад худалдааны бичиг баримтын цахим солилцоогоор дэмжих нь" сэдвээр хэлэлцүүлэг илтгэл тавьсан. - ГУАБ Ч.Эрдэнэбат, багш-ГУБ Д.Булгантамир гааль судлалын хүрээнд ДГБ-ын Ази Номхон далайн бүсийн сургалтын менежментийн эмхэтгэлд ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвийн үйл	01.01-06.10	100

					ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэн нийтлүүлсэн ба уг эмхэтгэл 2025 оны 05 дугаар сард нийтлэгдсэн. -ГУАБ Л.Олонбаяр, ГУАБ Ч.Эрдэнэбат нар ГХЯ, НҮБ-ын АНДЭЗНК болон ЕХ-ны Монголын гадаад худалдааг дэмжих төсөлтэй хамтран 3 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд "Монголын цахим худалдааны долоо хоног" арга хэмжээг зохион байгуулсан сургалтад ажиглагчаар оролцсон.		
4	Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалт 1 удаа /60 хүн/зохион байгуулна. 2. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт 2 удаа /150 хүн/зохион байгуулна.	- 2025 оны эхний хагас жилд ГЕГ-аас МУИС-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд ГБМ-ийн анхан шатны сургалтын хөтөлбөр хамтран гаргаж, МУИС-ийн захирал профессор Н.Батнасангай хамтран баталсан. Энэхүү батлагдсан хөтөлбөрийн дагуу 2025 оны 5, 6 дугаар саруудад ГБМ-ийн анхан шатны 2 удаагийн сургалт явагдсан болно. - ГЕГ-аас ДХИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 оны I, II улиралд ДХИС-ийн "Эрх зүй" бакалаврын IV дамжааны 25 оюутан "Гааль судлал" мэргэшүүлэх багцын гаалийн чиглэлээр дадлагын ажил хийхэд төвийн багш нар мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан. - Сургалтын төвөөс 2025 оны эхний хагас жилд ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө, удирдлагаас өгсөн чиглэл болон "Гаалийн зуучлагч байгууллагын холбоо" ТББ-ийн хүсэлтийн дагуу гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт – 3 удаа, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт – 3 удаа тус тус зохион байгуулсан ба сургалтад нийт 353 суралцагч хамрагдаж, 98,3 хувийн амжилттай дүгнэгдсэн болно. Сургалт бүрийн өмнө сургалтын хөтөлбөр, хичээлийн хуваарийг боловсруулан, төвийн даргаар баталгаажуулж ажиллаж ирсэн. Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу Сургалтын төвийн үндсэн багш нараас гадна ГЕГ-ын ЗББНДБ-ын чиглэл хариуцсан албан хаагч -зочин багш нар нийт 600 цагийн хичээл заасан. - Багш-ГУАБ Л.Олонбаяр МУИС-ийн Бизнесийн сургуулийн "Гаалийн менежмент" -ийн хөтөлбөрийн 12 оюутны дипломын ажлыг хамгаалуулах төгсөлтийн шалгалтын комиссын гишүүнээр 2025 оны 05 сарын 19-нд ажилласан. - Багш-ГУБ Н.Анужин 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр МУИС-ийн Бизнесийн сургуулийн "Худалдаа" хөтөлбөрийн оюутнуудын үйлдвэрлэлийн дадлага хамгаалалтанд гаалийн байгууллагаас төлөөлөн оролцож, 12 оюутны тайланг хамгаалуулсан. - Багш-ГУБ Ч.Жаргалсайхан, Н.Анужин нар ИЗОУИС-ийн Санхүү, эдийн засгийн сургуулийн "Гаалийн менежмент, Гааль татвар эдийн засаг" -ийн хөтөлбөрөөр суралцдаг 90 оюутны улсын шалгалт, дипломын ажлыг хамгаалуулах төгсөлтийн шалгалтын комиссын гишүүнээр 2025 оны 04 сарын 19, 05 сарын 02 болон 04-ний өдрүүдэд ажилласан.	01.01-06.10	100

					- Багш-ГУБ О.Отгонгэрэл, Г.Тамир, Н.Анужин нар 2025 оны 05 дугаар сарын 22-нд Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн харьяа Бизнес консалтинг төвөөс зохион байгуулсан "JOB&CAREER Fair 2025" мэргэжил сурталчлах өдөрлөгт гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлого хөтөлбөрийг танилцуулж, оролцсон.		
5	Багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. УА-ийн "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт"-д 1 багшийг хамруулна. 2. Сургалтын төвийн багш бүр өөрийн заадаг хичээлээр сургалтын хөтөлбөрийг цаг үетэй нийцүүлэн боловсронгуй болгож, шинэчилсэн байна.	- Багш-ГУБ Ж.Жаргал-Эрдэнэ, Д.Булгантамир нар Удирдлагын академийн "Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт"-д 2025 онд суралцаж, амжилттай төгссөн. - Багш-ГУБ Н.Нямгэрэл, Н.Анужин нар өөрсдийн багшлах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор МУБИС-ын Боловсрол Судлалын Сургуулийн багшлах мэргэжил олгох сургалтад 2025 оны 4,5 сард хамрагдан, амжилттай төгсөн, сертификат авсан. - Багш-ГУБ Н.Анужин нь Үндэсний тагнуулын академийн эрх зүйн бакалаврын эцнээ хөтөлбөрт хамрагдан, 2025 оны хаврын улирлыг амжилттай суралцаж төгссөн. - ГУАБ Л.Олонбаяр нь өөрийн докторантын сэдвийн хүрээнд МУИС-ийн Бизнесийн сургуулиас 2025 оны 05 дугаар сарын 02-нд зохион байгуулсан МУИС-ийн профессор, доктор Я.Отгонсүрэнгийн нэрэмжит "Маркетинг, худалдааны хөгжлийн асуудлууд" үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд "Гадаад худалдааны нэг цонхны системийг хэрэгжүүлж бусад орнуудын туршлага. Монгол улсын авах сургаж" сэдвээр, мөн МУИС-ийн Бизнесийн сургуулиас 2025 оны 05 дугаар сарын 16-нд зохион байгуулсан МУИС-ийн захирал, профессор, доктор Н.Батнасан, доктор Н.Отгонсайхан нарын нэрэмжит профессорын хэлэлцүүлэгт "Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг гадаад худалдааны бичиг баримтын цахим солилцоогоор дэмжих нь" сэдвээр тус тус илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. - ГУАБ Л.Олонбаяр, ГУАБ Ч.Эрдэнэбат, ГУБ Н.Нямгэрэл, Н.Анужин нар ГХЯ, НҮБ-ын АНДЭЗНК болон ЕХ-ны Монголын гадаад худалдааг дэмжих төсөлтэй хамтран 3 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд "Монголын цахим худалдааны долоо хоног" арга хэмжээг зохион байгуулсан сургалтад ажиглагчаар оролцсон. - Багш ГУБ Г.Тамир, Д.Булгантамир нар ОХУ-ын ИСБ-А ХХК-ийн Рентген тоног төхөөрөмжийн сургалтад сургагч багшаар бэлтгэгдэн, 2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд танхимын сургалт, 2025 оны 06 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд Замын-Үүд дэх гаалийн газарт зохион байгуулагдсан практик сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн. - Багш-ГУБ С.Ариунаа нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2025 оны 02 сарын 28-нд зохион байгуулсан "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хил дамнуулан хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх"	01.01-06.10	100

					болон 2025 оны 04 дүгээр сарын 24-нд зохион байгуулсан "Хилээр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хойшлуулашгүй ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хангаж, хүний эрхийг хамгаалах чиглэлээр туслалцаа үзүүлэх" сэдэвт вебинаруудад тус тус хамрагдсан. - Багш-ГУБ Ж.Жаргал-Эрдэнэ, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.6.3, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд ГЕГ-ын Ёс зүйн хороо болон Удирдлагын академи хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд хамрагдан, "Ёс зүйн сургагч багш" болсон. - Багш-ГУБ О.Отгонгэрэл, Н.Нямгэрэл, Н.Анужин нар 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэсэн "Мөнгө угаах гэмт хэрэг" -ийн сэдвээр ХТМУТХ-ээс зохион байгуулсан 6 удаагийн сургалтад хамрагдсан. - Багш-ГУБ Н.Нямгэрэл. ДГБ-ын Тариф, худалдааны газрын техникийн газар, Барааны ангилал, үнэлгээний хэлтэсээс хамтран зохион байгуулсан "Барааны ангилал болон ангиллын урьдчилсан шийдвэр" сэдэвт сургалтад 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд хамрагдаж сертификат авсан. - Багш-ГУБ Н.Анужин өөрийн заадаг хичээл болох гаалийн тариф, гаалийн татварын чиглэлээр гаалийн бүрдүүлэлтэд тулгамдаж буй мэдлэг, мэдээлэл олж авахаар ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд 2025 оны 03 сарын 13-ны өдрөөс хоёр долоо хоногийн турш бичиг баримт хариуцсан гаалийн улсын байцаагчийг дагалдан, импортын барааны гаалийн үнэлгээ хийх болон үнэлгээний маргаан шийдвэрлэх үүргүүдэд тус тус томилогдон ажилласан.		
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	- Дэлхийн Гаалийн Байгууллагаас 2024 оны 5 дугаар сарын 5-наас 10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Паласамудрам хотноо Ази, Номхон далайн бүсийн гаалийн байгууллагуудын сургалтын менежментийн уулзалтыг зохион байгуулсан. Тус сургалтын үр дүнд Монгол Улсын гаалийн байгууллага 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа Дэлхийн Гаалийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвд хүргүүлж, шилдэг туршлагын нэгээр шалгарсан. Энэ хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 21-нд Хонконг улсад зохион байгуулагдсан Дэлхийн Гаалийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн гаалийн байгууллагын дарга нарын 26 дугаар бага хурлаар Монгол Улсын илтгэлийг албан ёсоор танилцуулсан бөгөөд мөн Дэлхийн Гаалийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн сургалтын менежментийн эмхэтгэлд Монгол Улсын тайланг тэргүүн туршлагаар хэвлүүлсэн. - Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журмыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр	01.01-06.10	100

				Гаалийн Ерөнхий Газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/138 дугаар тушаалаар баталсан. Мөн гаалийн асуудлаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын хоёр талт хэлэлцээрүүдийн дүн шинжилгээг хийж, "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар болон бусад орны Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудалд онцгой анхаарч, зарим орны хоёр талт Засгийн газар хоорондын хэлэлцээрт онцгой сонирхлын барааны жагсаалтыг тодорхойлсон бөгөөд ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хоёр талт хэлэлцээрт контрабандын халдлагын зүйлсийг тусгасан. - Олон улсын валютын сан (IMF)-гийн Техникийн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн багаас ирүүлсэн зөвлөмж бүхий холбогдох тайлан, мэдээлэлтэй танилцаж Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэст саналаа хүргүүлсэн. -Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагаанд ISO 9001:2015 болон ISO 27001:2022 стандартын хэрэгжилтэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх "Ажлын даалгавар"-ын төслийн 9 дүгээр бүлэг "Гүйцэтгэлийн үнэлгээ" хэсэгт санал хүргүүлсэн.		
8	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Нэгжийн сургалтын эрсдэлийг тооцож ажиллах талаар арга хэмжээ авч ажиллах 2023 оноос явагдаж буй дунд хугацааны сургалтад /ГУБ, ГБМ-ийн анхан, давтан/ багш нарыг ээлжлэн ангийн багшаар томилон ажиллуулж байгаа нь сургалтын гэрээ байгуулах, төлбөр хураах, , бусад олон нийтийн ажлыг ямар эрсдэл үүсэхгүйгээр зохион байгуулах боломжийг олгож байгаа сайн талтай юм. 2025 оны эхний хагас жилд ГБМ-ий анхан болон давтан 4 сургалт зохион байгуулагдаж, нийт 244 суралцагч хамрагдсан. Эдгээр суралцагч нартай ГЕГ-ын даргын А/341 тушаалаар 2022 онд батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 3.7 заалтын дагуу сургалтын гэрээг байгуулж, ИТААҮА-ны ГУАБ А.Болор-Эрдэнэд бусад шаардлагатай материалын хамт хүлээлгэн өгч, сургалтын төлбөр 98400000 төгрөгийг Төрийн сан дахь ГЕГ-ын 100900011031 дансанд төвлөрүүлсэн. Мөн МУИС-тай хамтран ГБМ-ий анхан төлбөрт сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулсан ба төлбөрийг тус сургалтын төлбөрийг МУИС-ийн Боловсролын санд төвлөрүүлсэн - Багш-гаалийн улсын байцаагчид өвчтэй, чөлөөтэй болон бусад хүндэтгэж үзэх шалтгааны улмаас хичээл заах боломжгүй болох эрсдэлийг тооцсоны үндсэн дээр нэг хичээлийн хөтөлбөрийг 2 ба түүнээс дээш багш зэрэг судлан, бие биенээ орлон, мөн хоршин ажиллах боломжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлыг ажлын байрны сургалт явуулахад анх туршиж эхэлсэн нь үр дүнтэй ажил болсон тул цаашид сургалтад энэхүү аргыг ашиглаж байна.	01.01-06.10	100

				- ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороод "Гааль судлалыг хөгжүүлэх" хөтөлбөр болон тухайн цаг хугацааны сургалтын төлөвлөгөөний биелэлтийн тайланг огт ирүүлдэггүй, хугацаа хоцроодрг зэрэг зөрчил, дутагдал гаргадаг тул энэхүү эрсдэлээс сэргийлж, төвөөс дараахь 2 арга хэмжээг авч ажилласан. Үүнд: 1. ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодыг багш нарт хуваарилж өгсөн 2. CERP програмаар ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодод тайлан ирүүлэх талаар хугацаатай үүрэг, даалгавар өгсөн -Багш бүхэн өөрийн заадаг хичээлдээ ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсээс гаргасан "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан 2023 "-аас зарим мэдээллийг ашиглаж байна.		
9	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. 2. Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. 2025 оны эхний хагас жилд удирдлагаас Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /ГЗДАС/ програмаар дамжуулан нийт 26 үүрэг даалгавар өгөгдсөн. Энэхүү үүрэг даалгаврыг төрлөөр нь ангилбал: - Үүрэг даалгавар - 8 - Зөвлөмж - 12 - Онлайн хурлын даалгавар – 2 - Захиргааны зөвлөлийн хуралдаан-1 - Ёс зүйн дэд хорооны хуралдаан – 1 - Цаг үеийн шинжтэй - 2 Төлвөөр нь задалбал: - "Илгээсэн "төлөвтэй" - 11, - "ХШҮДАГ дүгнэсэн" төлөвтэй – 13 - Нэгж дүгнэсэн – 1 - Биелэлт оруулаагүй – 1 /хугацаа болоогүй/ ГЕГ-ын удирдлага -1, ХШҮДАХ-ээс – 12, ЗУГ-аас – 9, ЭУХ-ээс 3, ТОГ- 1 удаа тус тус үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг цаг хугацаанд нь програмд 100 хувь оруулж, дүгнэгдсэн байна. Мөн Сургалтын төвөөс 2025 онд ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар, хороодод сургалтын тайланг ирүүлэх талаар 2 үүрэг даалгавар хүргүүлсэн ба үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь дүгнэж, програмд оруулсан. 2025 оны эхний хагас жилд ГЕГ-ын дарга, дэд дарга, ГЕГ-ын ЗББНДБ-аас EDос програмаар 160 албан бичиг, дотоод зурвас ирсэн бөгөөд үүнээс 148 бичгийн хариуг шийдвэрлэсэн, 12 бичгийн хариу "Судалж байгаа" төлөвт байна. "Хугацаа дөхсөн" болон Хугацаа хэтэрсэн" төлөвтэй албан бичиг байхгүй бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байна. Мөн	01.01-06.10	100

					энэхүү тайлант хугацаанд төвөөс бусад газар, хэлтэс, байгууллага руу ийт 85 албан бичиг хүргүүлсэн болно.		
10	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна. 2. Ажлын цаг ашиглалт өссөн/ буурсан үр дүн, шалтгаан нөхцлийг тайлагнана.	2025 оны эхний хагас жилд дарга, ГУАБ -2, багш ГУБ - 8, номын санч-архивч -1 нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Тайлант хугацаанд ажиллавал зохих нийт 124/11904 хүн/өдөр/хоногоос: - Өвчтэй – 1 албан хаагч /5хоног, 40 хүн/өдөр/ - Чөлөөтэй - 2 албан хаагч /32 хоног, 256 хүн/өдөр/ - Бусад албан хаагчид цаг ашиглалтыг бүрэн хангаж ажилласан байна.Төвийн хэмжээнд ажлын цаг ашиглалт – 97,5 хувьтай байна.	01.01-06.10	100
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Эхний хагас жилд: 1. ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдлага арга зүйгээр хэрхэн хангаж ажилласан байдал, үр дүнг, 2. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, нэгжийн үйл ажиллагаанд ашиглагддаг програмын шинэчлэлт, хөгжүүлэлт, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан болон бүрэлдэхүүнд нь ажилласан байдал, аливаа зөвлөмжийн биелэлт зэрэг арга хэмжээг тус тус тайлагнана.	- ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдлага арга зүйгээр хангаж ажиллах ажлын хүрээнд "Гааль судлал хөгжүүлэх хөтөлбөр" болон ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хангах, хяналт тавих багш нарын хуваарилалт"-ыг баталснаар багш бүр өөрийн хариуцсан ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодын сургалтын болон холбогдох бусад үйл ажиллагаанд хяналт тавьж, ажилласнаар үүрэг, даалгаврын биелэлт цаг хугацаандаа гүйцэтгэгдэх боломж эрс сайжирсан. Сургалтын төвөөс 2025 оны эхний хагас жилд ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодод сургалт, гааль судлал, ГЕГ, МУИС-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлэх талаар нийт 7 үүрэг даалгавар хүргүүлсэн ба үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь дүгнэж, програмд оруулсан. - ГЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/249 дугаар тушаалын "Гаалийн улсын байцаагчийн ажлын үр дүнг дүгнэх журам"-ын 2 дугаар хавсралтын дагуу ГУБ нарын ажлын үзүүлэлтийг 2025 оны I, II улирлын байдлаар дүгнэж, нэгтгэн, ЗУГ-т цаг хугацаанд нь хүргүүлсэн. Нийт 10 албан хаагч /ГУАБ -2, ГУБ -8/ дүгнэгдсэнээс "А" дүнгээр -10 албан хаагч тус тус үнэлэгдсэн байна. - Төвийн албан хаагчид ГЕГ-ын ЗУГ- аас зохион байгуулдаг баасан гаригийн "Мэдээллийн цаг" арга хэмжээнд бүрэн хамрагдаж байсан. Энэхүү "Мэдээллийн цаг" арга хэмжээнд төвийн зүгээс 2025 оны 4 дүгээр сард "Төрийн албан хаагчийн сэтгэл зүйн хам шинж" сэдвээр мэдээлэл өгсөн. - ГЕГ болон Гаалийн ахмадын хорооны хамтран ажиллах 2025 оны гэрээний төлөвлөгөөний дагуу ментор багш Гаалийн итгэмжит зөвлөх С.Энхтуяа тус төвийн залуу багш нарт гаалийн чиглэлээр сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, ажилласан.	01.01-06.10	100

					- Төвийн ГУАБ Ч.Эрдэнэбат 2025 оны 02 дугаар сард ГЕГ-ын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан. - Багш ГУБ Н.Анужин 2025 оны 05 сарын 29-ний өдөр "Гааль подкаст"-ын хоёрдугаар дугаарт "Гаалийн албанд залуу үеийн оролцоо" сэдвээр ярилцлага өгч, оролцсон. - Гаалийн байгууллагын хэмжээнд 2025 оны 04 дүгээр сарын 25-29-нд зохион байгуулагдсан "Спортын наадам 2025" арга хэмжээнд төвийн дарга Ч.Мөнххишиг гар бөмбөгийн төрлөөр мөнгөн медаль, ГУАБ Л.Олонбаяр ширээний теннисний төрлөөр алтан медаль хүртсэн амжилт үзүүлсэн. - Сангийн яамны харъяа байгууллагуудын дунд 2025 оны 06 дугаар сарын 05-08-нд зохион байгуулагдсан "Спортын наадам 2025" арга хэмжээнд ГУАБ Л.Олонбаяр ширээний теннисний төрлөөр мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлсэн.		
12	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	2025 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.	Төвийн албан хаагчид 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд АТГ-т мэдүүлэн, Гаалийн ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. - 2025 эхний хагас жилд АТГ-ын комиссар Д.Золжаргал, Сургалтын төвийн багш Ж.Жаргал-Эрдэнэ нар сургалтын хөтөлбөрийн дагуу "Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигын гэмт хэрэг" сэдвээр нийт 10 удаагийн 22 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 580 албан хаагч хамрагдсан байна.	01.01-06.10	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	"Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр" сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	ОУВС-аас Камбожи улсад зохион байгуулсан "Гаалийн шинэчлэл, өөрчлөлт" бүс нутгийн уулзалт, сургалтад оролцож, гэрчилгээ авсан.	Хөтөлбөрт хамрагдсан байна.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.	01.01-06.10	100

2	"Дэлхийн түвшний менежер 1" сургалтад цахимаар хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	ДГБ-ын цахим сургалтын платформ дээр "Удирдлагын хөгжил, манлайлал" сургалтыг үзэж судлан, цахим гэрчилгээ авсан.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Сургалтад сүүлийн хагас жилд хамрагдахаар төлөвлөсөн.	01.01-06.10	100
3	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдаж, тэнцсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	Өмнө нь сургалтад хамрагдаж байгаагүй.	Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Сургалтад сүүлийн хагас жилд хамрагдахаар төлөвлөсөн.	01.01-06.10	100
4	ДГБ-ын цахим сургалтын модулиас "Middle Management Development" хичээлийн модуль 2-ыг орчуулах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Сургалтын Модуль 2 "Багаа удирдахуй" хичээлийг орчуулсан байна.	ДГБ-ын "Дунд түвшний удирдлагын хөгжил "Middle Management Development" Модуль 2 "Багаа удирдахуй" хичээлийн 4 модуль хичээлийг англи хэлнээс орчуулсан.	01.01-06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

СУРГАЛТЫН ТӨВИЙН

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.МӨНХХИШИГ/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.МӨНХХИШИГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Сургалтын төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		58,3

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	"Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр" сургалтад хамрагдах		15
2	"Дэлхийн түвшний менежер 1" сургалтад цахимаар хамрагдах		15
3	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдаж, тэнцсэн байна		15
4	ДГБ-ын цахим сургалтын модулиас "Middle Management Development" хичээлийн модуль 2-ыг орчуулах		15
Дундаж оноо:			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
	1	3
1	Хандлага, ёс зүй	13
2	Дүн шинжилгээ хийх	13
3	Асуудал шийдвэрлэх	12
4	Хариуцлагатай байдал	13

5	Ажлын цаг ашиглалт	13
	Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)	
6	Мэргэжлийн ур чадвар 1	
	Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо	13

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	58,3
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
4	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		86,3

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч:

(Р.Отгонжаргал)

2025.06.25.....(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Ч.Мөнххишиг)

2025.06.10.....(огноо)